

ИНТЕЛЛИГЕНЦИЯ И ПРОБЛЕМЫ ПАТРИОТИЧЕСКОГО И ИНТЕРНАЦИОНАЛЬНОГО ВОСПИТАНИЯ МОЛОДЕЖИ

© *Октябрь Нэмэхханд Лувсандаш*

доктор наук (PhD), профессор кафедры военной психологии Пограничного института Университета правоохранительной службы Монголии

Монголия, г. Улан-Батор

E-mail: bti1125@yahoo.com

Военная организация является комплексом многосторонних отношений экономики, юриспруденции, нравственности и управления, которая стала особой системой социального института. Мы считаем, что нельзя характеризовать офицеров-пограничников интеллигентами, как только они окончили институты, а лучше их называть квалифицированными кадрами. Трудовая деятельность, специальность офицеров-пограничников схожи друг с другом и в соответствии с этим они являются профессиональной общностью, связанные между собой общими интересами, образом жизни, социальными функциями, целью и деятельностью. В связи с формированием этой профессиональной общности независимость и безопасность страны понимается в тесной связи с ними и в соответствии с уровнем общественного развития, место, которое они занимают в обществе, представляется по-разному. Существует такая особенность, что ценности офицеров-пограничников соответствуют государственным и общественным ценностям. И поэтому по сравнению с другими общественными группами перед ними ставятся высокие нравственные требования. Одним словом офицеры-пограничники должны сформировать у себя высокую нравственность, показывать пример другим, их отношение к работе должно быть ответственным и аккуратным. Все эти качества не только являются социальной особенностью военных, которая отличает их от других общественных групп, но и становится образом «интеллигента».

Ключевые слова: военная организация, система социального института, офицеры-пограничники, профессиональная общность, общественная ценность.

ХИЛЧИН ОФИЦЕРУУДАД ЭХ ОРОНЧ ҮЗЭЛ БА СЭХЭЭТНИИ ДУР ТӨРХ ТӨЛӨВШҮҮЛЭХ АСУУДАЛД

Лувсандаш овогтой Октябрийн Нэмэхханд

Улаанбаатар хот, Монгол улс

Цэргийн салбар нь нийгмийн нийтлэг, биеэ даасан нийгмийн нэг институтын хувьд социологийн судалгааны объект болдог. Нийгмийн хамтын үйл ажиллагааны зохион байгуулалтын түүхэн есоор бүрэлдэн бий болсон тогтвортой хэлбэрийг социологичид нийгмийн институт гэдэг ухагдахуунаар тодорхойлон авч үздэг [3, х. 7]. Цэргийн байгууллага бол эдийн засаг, хууль зүй, ес суртахуун, удирдлагын олон талын харилцааны нийлбэр цогц болох нийгмийн/социаль/институтын систем юм. Нийгмийн институтууд гүйцэтгэх үүргээрээ өөр хоорондоо ялгагдана [3, х. 7]. Нийгмийн институт нь тухайн чиг үүргийг зүгээр нэг гүйцэтгэх биш харин аль нэг институтын дотор тогтож хэвшсэн зан үйлийн стандарт, зайлшгүй дагах хэм хэмжээний дагуу биелүүлдэг. Агуулга талаас нь авч үзвэл нийгмийн институт нь түгээмэл орчин нөхцөлд хүмүүсийн дагаж мөрдөх зан үйл, хэм хэмжээ юм [2, х. 48].

Нийгмийн институт бүр үйл ажиллагааны өөрийн гэсэн зорилготой, үүнийгээ хэрэгжүүлэх тодорхой арга хэрэгсэлтэй, мөн дотроо байр суурийн шатлалтай байдаг. Энэ нь цэргийн алба, удирдлагын босоо тогтолцоог илэрхийдэг гэж хэлж болно. Нөгөө талаар нийгмийн институт нь хүмүүст хэрэгцээгээ хангах, өөр хоорондоо зохицон нэгдэх боломж олгон нийгмийн харилцааг тогтворжуулж өгдөг.

Цэргийн алба нь цэргийн жинхэнэ болон бэлтгэл албанаас бүрдэх бөгөөд хуулинд зааснаар армид цэргийн үүрэг гүйцэтгэхийг цэргийн жинхэнэ алба гэдэг” [4]. Үүнээс үзвэл цэргийн жинхэнэ албанд алба хааж буй төрийн албан хаагчдыг цэргийн албан хаагч хэмээн нэрлэдэг байна. Цэргийн албан хаагч гэдэгт офицер, ахлагч, байлдагч, түрүүч нарыг багтаан ойлгодог.

Оросын академич Д. С. Лихачевийн тодорхойлсноор «Их дээд сургууль төгссөн, дээд боловсролтой, оюуны бүтээлч хөдөлмөр

эрхэлдэг хүмүүсийн нийтлэгийг сэхээтэн гэнэ» хэмээн бичсэн байдаг. Энэ тодорхойлолтоор бол манай хил хамгаалах байгууллагад офицерууд нь сэхээтэн бөгөөд их дээд сургууль төгсөөгүй ахлагч, байлдагч, түрүүч нарыг сэхээтэн биш гэж тодорхойлоход учир дутагдалтай. Гэвч хилчин офицеруудыг заавал их дээд сургууль төгссөнөөр нь сэхээтэн гэж тодорхойлохоосоо илүү мэргэшсэн боловсон хүчин гэж тодорхойлох нь илүү зохимжтой хэмээн үзэж байна.

Хүн төрөлхтний хөгжлийн эрт үед «цэрэг» гэх зэвсэглэсэн нийгмийн бүлэг үүсч бий болсон нь одоог хүртэл өөрийн өвөрмөц онцлогтой, нийгмийн бусад бүлгээс ялгагдах ялгаа бүхий биеэ даасан социаль бүлэг байсаар байна. Энэ нь «нийгмийн нийтлэг» гэх ойлголтыг төрүүлдэг.

Мөн хилчин офицерууд нь нийгмийн нийтлэг болох тухай дээр дурьдсан. Нийгмийн нийтлэг нь социологийн шинжлэх ухааны үндсэн ухагдахуун юм. Нийгмийн нийтлэг гэдэг нь нийгмийн ахуй үйл ажиллагаагаараа нөхцөлдсөн, ашиг сонирхол хэрэгцээ, хүсэл мөрөөдөл, үзэл бодол, зан заншил уламжлалын ойролцоо байдлаараа холбогдсон, нийгмийн дотор хамтдаа харьцангуй нэгэн бүхэл шинжийг агуулж бодитой тогтвортой оршин байдаг, түүхийн болон нийгмийн үйл ажиллагааны бие даасан эзэн болдог хэсэг бүлэг хүмүүс юм [1, с. 13].

Нийгэмд маш олон төрлийн нийтлэг байдаг. Тухайлбал, нийгэм хүн ам зүйн шинжээрээ өөр хоорондоо ялгагдах нийгмийн бүлгүүд, гэр бүл, залуу ба ахмад үеийнхэн, мэргэжил, эрхэлдэг ажил, нийгмийн үйл ажиллагаагаараа ялгагдах хөдөлмөрийн хамт олон, тодорхой мэргэжлийн янз бүрийн хүмүүсийн хэсэг, оршин амьдарч буй газар нутаг, байршлаараа хотынхон, хөдөөгийнхөн, хангай, говийнхон гэх мэт нийгмийн нийтлэгүүд байдаг. Нийгмийн нийтлэг бол бие хүнийг нийгэмтэй холбож, тэдгээртэй болон хоорондоо маш олон хэлхээгээр холбогдож харилцан үйлчилж байж оршино [3]. Иймд хилчин офицерууд нь эрхэлж буй хөдөлмөрийн үйл ажиллагаа, мэргэжлээрээ өөр хоорондоо адил төдийгүй үүнийгээ дагаад хүсэл сонирхол, амьдралын хэв маяг, нийгмийн үүрэг зорилго, үйл ажиллагаагаараа холбогдсон ажил мэргэжлийн нийтлэг юм.

Нийгэмд энэхүү өвөрмөц онцлогтой нэгэн мэргэжлийн нийтлэг бий болсноор улс орны аюулгүй байдал, тусгаар тогтнол тэдэнтэй салшгүй

холбоотойгоор ойлгогдох болж нийгмийн хөгжлийн түвшинтэй уялдан тэдний нийгэмд эзлэх байр суурь харилцан адилгүй байсаар иржээ.

Хилчин офицеруудын хувьд тэдний хөдөлмөрийн онцлог, амьдралын хэв маяг, албандаа хандах хандлага, үнэлэмж баримжаалал, ес зүйн төлөвшилт зэрэг нь нийгмийн бусад бүлгийнхнээс ялгаатай, өвөрмөц онцлогтой байдаг. Нэгэнт л цэргийн мэргэжлийг сонгосон бол тэдний хувьд юу хийх, ямар даалгавар, хэзээ гүйцэтгэх, хаана ажиллах гэх зэрэг нь бүгд тодорхой тушаал, заавраар зохицуулагддаг. Зөвхөн тэдэнд энэ шаардлага тавигдаад зогсохгүй тэдний гэр бүлийнхэнд ч мөн энэ нь хамааралтай байдаг. Ийм учраас цэргийн албан хаагчид өөрийн оршин амьдрах газар нутгаа болон гүйцэтгэх үүрэг зэргээ сонгох боломжгүй байна. Мөн түүнчлэн өөрийн хувийн эрх ашиг, амжилтаа эрмэлзэх боломж нийгмийн бусад бүлгийнхэнтэй харьцуулбал бага байдаг. Иймд хилчин офицеруудын гавъяаг үргэлж хүндэтгэдэг байна. Учир нь хилчин офицеруудтай улс орны аюулгүй байх хувь заяаг холбон ойлгодог юм.

Хилчин офицеруудын эрхэмлэх үнэт зүйл, үнэлэмж баримжаалал нь нийгмийн буюу төрийн (нийтийн) үнэт зүйл үнэлэмжтэй давхцах юмуу эсвэл ойролцоо байдаг онцлогтой.

Үүнээс гадна нийгмийн бусад бүлгийнхэнтэй харьцуулахад тэдэнд тавигдах ес зүйн шаардлага өндөр байдаг. Өөрөөр хэлбэл хилчин офицерууд бусад үлгэр дууриал үзүүлэхүйц өндөр ес зүйтэй, ажил албандаа хандах хандлага нь нягт нямбай, хариуцлагатай байхыг шаарддаг онцлогтой. Энэ бүхэн нь цэргийнхний нийгмийн бусад бүлгээс ялгагдах социаль онцлог болохын зэрэгцээ мөн “Сэхээтэн”-ий төрх болдог.

Түүхийн өнгөрсөн үеүдэд цэрэг армийнхний нэр хүнд өндөр, нийгэмд эзлэх байр суурь нь нийгмийн бусад бүлгийнхнээс илүүтэй байсан нь бий. Манай улсын хувьд, цэрийнхнийг түүхийн бараг л бүх үедээ хүндэтгэн, тэдний дайчин уламжлал, сүр хүчээр бахархаж иржээ. Ялангуяа офицеруудад хандаж байсан иргэдийн хандлагын оюун санааны тал нь үндэсний эх оронч үзэл, хүмүүжлийг залуу хойч үеийнхэнд төлөвшүүлдэг байсантай холбоотой. Энэ хандлага бараг 1980-аад оны төгсгөл хүртэл зонхилж байв.

Харин 20-р зууны ерээд оноос нийгмийн тогтолцоо өөрчлөгдсөнтэй холбоотойгоор хуучин үнэлэмж, үнэт зүйлийн тогтолцоонд өөрчлөлт орж аливаад эргэлзэх, шүүмжлэх уур амьсгал нийгмийн сэтгэл зүйд бий болсон нь офицеруудын дунд ч мөн илэрч байв. Өнөөдөр

офицеруудад хандах олон түмний хандлага өөр болсон. Энэ нь нэг талаар өөрийн орны нийгмийн хөгжлийн түвшин хандлага, нөгөө талаас дэлхий дахинд хийгдэж буй цэргийн шинэчлэлтэй холбоотой.

Нийгмийн аюулгүй байдлыг хангах хэрэгслүүдийн дотор хил хамгаалах байгууллагын офицерууд 3; 4-р байранд орж харин боловсрол, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн салбарууд болон ард түмний амьдралын түвшингийн үзүүлэлт зэрэг нь тэргүүлэх байранд гарч ирлээ.

Гэхдээ дээр дурьдсан бүхэнтэй уялдан хилчин офицерууд буюу сэхээтний дүр төрхөд мөн өөрчлөлт орж байна. Ингээд хилчин офицеруудын буюу сэхээтнүүдийн нийгмийн төрхийг илтгэн харуулахуйц гол шинж тэмдгүүд болох тэдний амьдралын хэв маяг, мэргэжил боловсролын байдал, албандаа хандах хандлага, амьдралын зорилго, үнэт зүйлсийн баримжаалал зэргийг авч үзэж байна. Судалгаанаас харахад эдгээр шинжүүд нь тэдний эх оронч үзэлд шууд утгаараа хамааралгүй гэж хэлж болох боловч эх оронч үзэл нь хилчин офицеруудын итгэл үнэмшил, сүслэн дээдлэх үнэт зүйлстэй нь холбоотой хэмээн үзэж санал дэвшүүлж байна.

Аль ч улс орны цэргийн албан хаагчдын хувьд тэдний хөдөлмөрийн онцлог, амьдралын хэв маяг, албандаа хандах хандлага, үнэлэмж баримжаалал, ес зүйн төлөвшилт зэрэг нь нийгмийн бусад бүлгийнхнээс ялгаатай, өвөрмөц онцлогтой байдаг. Нэгэнт л цэргийн мэргэжлийг сонгосон бол тэдний хувьд юу хийх, ямар даалгавар, хэзээ гүйцэтгэх, хаана ажиллах гэх зэрэг нь бүгд тодорхой тушаал, заавраар зохицуулагддаг. Зөвхөн тэдэнд энэ шаардлага тавигдаад зогсохгүй тэдний гэр бүлийнхэнд ч мөн энэ нь хамааралтай байдаг. Ийм учраас цэргийн албан хаагчид өөрийн оршин амьдрах газар нутгаа болон гүйцэтгэх үүрэг зэргээ сонгох боломжгүй байна. Мөн түүнчлэн өөрийн хувийн эрх ашиг, амжилтаа эрмэлзэх боломж нийгмийн бусад бүлгийнхэнтэй харьцуулбал бага байдаг.

Хилчин офицеруудын эрхэмлэх үнэт зүйл, үнэлэмж баримжаалал нь нийгмийн буюу төрийн (нийтийн) үнэт зүйл үнэлэмжтэй давхцах юмуу эсвэл ойролцоо байдаг онцлогтой ажээ.

Аливаа мэргэжил бүр өөрийн онцлог шинжийг агуулсан байдаг. Энэ утгаараа ч ажил албандаа тодорхой амжилт гаргахын тулд тухайн мэргэжлийн онцлогт тохирсон чадварыг эзэмших хэрэгтэй болдог. Тэгвэл хилчин офицеруудад зайлшгүй байх естой чанаруудаас Та алинтай нь санал нийлж байна вэ? гэж хил хамгаалах байгууллагын

удирдах албан тушаалын офицеруудаас асуугаад доорх боломжит сонголтуудыг өгөхөд/1–2 хувилбар сонгуулсан/

Таблица 1

Тэсвэр хатуужилтай, шударга зарчимч бөгөөд эх орончид байх естой гэж үзсэн байна (%)

1	Тэсвэр хатуужилтай	48,05
2	Эх оронч	38,96
3	Шударга зарчимч	32,46
4	Хөдөлмөрч	22,07
5	Овсгоо самбаатай	16,88
6	Санаачлагч	12,98
7	Оримог	7,79
8	Чадварлаг	6,49
9	Мэдрэмжтэй	5,19
	Ю. Туршлага дадлагатай	2,59
	Тус тус сонголт хийсэн байна	
	Дээрх дүнгээс үзэхэд ихэнх цэргийн албан хаагчид цэргийн хүн бол	

Мөн тэсвэр хатуужил хэмээх сонголтын эзлэх хувь бусад сонголтуудаас харьцангуй их байгаа нь цэргийн алба ихээхэн тэсвэр хатуужил шаарддаг хөдөлмөр гэдэг нь ч тодорхой харагдаж байна. Энэ асуултыг өмнөх асуулттай харьцуулахад нэгэн сонирхолтой зүйл ажиглагдсан юм. Тодруулбал цэргийн хүн эх оронч байх естой гэсэнтэй санал нийлсэн хүн 38,96% байхад, эх орноо эрхэмлэн хүндэтгэдэг үнэт зүйлээ гэж боддог цэргийн албан хаагчид 29,87% байлаа. Мөн дээрх хоёр ойлголтын хамаарлыг харьцуулахад өмнөх асуултын эх орон хэмээх үнэт зүйлийг сонгосон хүмүүсийн 73,32% нь цэргийн албан хаагчид эх оронч байх естой гэж хариулсан байлаа. Үүнээс үүдээд эх орноо эрхэмлэн хүндэтгэдэг үнэт зүйлээ гэж боддог хүмүүс эх оронч үзэлтэй байна гэсэн зүй тогтолтой гэж үзэж болохоор байна.

Социологид хилчин офицеруудын эх оронч үзэл, эх оронч байр суурь, үйл явцыг судлахдаа нийгмийн ухамсар, хүмүүсийн зан төлөвийн хэв маяг, нийгмийн бүтэц, эрх үүрэг статус, соёлын загварт гарч буй гол өөрчлөлтүүдэд анхаарлаа хандуулдаг байна.

Ном зүй

1. Бинъяа Л. Социологийн шинжлэх ухааны онолын үндэс. – УБ., 1994.
2. Самыгин С. И., Перов Г. О. Нийгэм судлал. – УБ., 2004.
3. Эрдэнэчулуун Ч. Цэргийн социологи. – УБ., 1998.
4. Монгол улсын зэвсэгт хүчний эрх зүйн үндэс. – УБ., 2002.

INTELLIGENTSIA AND PROBLEMS OF PATRIOTIC INTERNATIONAL EDUCATION OF YOUTH

Nemekhkhand Luvsandash Oktyabr

Doctor of Sciences, Professor, Department of Military Psychology,
Institute of Borders of the Law Enforcement University of Mongolia
Ulaanbaatar, Mongolia
E-mail: bti1125@yahoo.com

Overall, military organization, being a complex of multilateral economic, judicial, moral and administrative relations, has become a unique system of the social institution. It is not appropriate to define officers of border forces as intelligentsia as soon as they graduate from the educational institutions, but rather qualified personnel. The nature of their work is similar; therefore they form a professional community, sharing common interests, lifestyle, social functions, goals and activities. Creating such a professional community means that sovereignty and safety of the country is closely related to them in accordance with the level of social development, the place assigned to them in the society may have different meanings. Also, values held by these officers are seen as inseparable from the values of the state and the society that is why moral standards expected from them are higher than of other social groups. In other words, officers from the border forces must hold high morals and be a role model to others, while their attitude to fulfilling their duties should be responsible and accurate. All of these factors not only serve as distinctive social characteristics of military personnel but also become an image of intelligentsia.

Keywords: military organization, system of social institute, Border guard officers, professional group, professional community, social status.